



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/940

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 09 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Замын хөдөлгөөний цагаан толгой” улсын уралдаанд амжилттай оролцож “Тусгай байр” эзэлсэн Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн багт унааны зардалд 500.000 (Таван зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардалд шаардагдах 500.000 (Таван зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100493